



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 02/24

Баян-Өндөр сум


**Аймгийн сонгуулийн хороо
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах аймгийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг аймгийн Сонгуулийн хороо (Ш.Ганболд)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХБАТ

6125010025

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025
оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Ээлжит II
хуралдааны 02/24 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Ш.Ганболд
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн
бичгийн дарга
- Гишүүд: - М.Жанболат
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- А.Лхагвадорж
Аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа
- М.Отгонбаяр
Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Д.Цолмон
Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын дарга
- С.Энхтүвшин
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч
- Нарийн бичгийн
дарга: - М.Мөнхбаяр
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн дарга